



НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН
АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2010 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

ШИНЭ БҮТЭЭЛЧ АЖЛУУДЫГ ДЭМЖИЖ
УРАМШУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын "Төсвийн байгууллагын удирлага, санхүүжилтийн тухай" хуулийн 12.1.5 дахь заалт, "Төрийн албаны тухай" хуулийн 19.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2010 оны 02 дугаар сарын 24 ны өдрийн 4/434 албан тоотыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2010 оны зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллага, нэгж, ажилтан нэг бүр дүрмээр хүлээсэн өдөр тутмын чиг үүргээс гадна иргэд, олон нийтэд хандсан шинэ, бүтээлч ажлыг сар бүр санаачилан хэрэгжүүлж, ажиллахыг нийт мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.

Хоёр. Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд иргэд, олон нийтэд хандсан шинэ, бүтээлч ажлыг сар бүр санаачлан хэрэгжүүлэх ажилд тогтмол хяналт тавьж, шинээр санаачилан зохион байгуулсан ажлыг сурталчлах, хүлээгдэж байгаа үр дүнгын талаарх мэдээ тайланг сарын бүрийн 25-ны дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлж ажиллахыг дэд дарга / Ч.Батсайхан /-д даалгасугай

Гурав. Иргэд, олон нийтэд хандсан шинэ, бүтээлч ажлыг сар бүр санаачлан хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн мэргэжилтэнг тухай байгууллагын даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн сарын үндсэн цалинг 5-10%-аар нэмэгдүүлэн олгож байхыг ня-бо / З.Сэргэлэн / -д зөвшөөрсүгэй



ДАРГА

Д.МӨНХЦОГ

My Documents tuchaal

0500 11